

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/2/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70373089
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Н.Хулансүрэн
Утас: 70373089
Цахим хаяг: Khulansuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059
Утас: 7037-3089 Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.14 № 43
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЧАДРААБАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд "Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэх" зорилтын хүрээнд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн байранд Жоб центр төвийг нээж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 17 бүлгийн сургалт хийж, авсан 3,420.0 мянган төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050050

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 220,363.5 мянган төгрөгийг төлөвлөж, зарцуулсан ба нийт 91 иргэн хамрагдаж, шинээр 31 иргэн ажлын байртай болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 89.25 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,222,905,795.32	2,542,907,872.97
33	АВЛАГА	2,222,905,795.32	2,542,907,872.97
33600	Зээлийн авлага	2,222,905,795.32	2,542,907,872.97
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	2,222,905,795.32	2,542,907,872.97
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,222,905,795.32	2,542,907,872.97
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,222,905,795.32	2,542,907,872.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	205,114,224.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	205,114,224.00
41300	Өглөг	-	205,114,224.00
41360	Бусад өглөг	-	205,114,224.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	32,181,224.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	172,933,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,222,905,795.32	2,337,793,648.97
51	Засгийн газрын хувь оролцоо	2,222,905,795.32	2,337,793,648.97
51200	Хуримтлагдсан үр дүн	2,222,905,795.32	2,337,793,648.97
51210	Өмнөх үеийн үр дүн	2,276,590,585.00	2,222,905,795.32
51220	Тайлант үеийн үр дүн	(53,684,789.68)	114,887,853.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,222,905,795.32	2,542,907,872.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,301,414,500.00	1,365,318,320.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,301,414,500.00	1,365,318,320.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,301,414,500.00	1,365,318,320.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,074,511,600.00	838,222,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	944,551,600.00	737,142,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129,960,000.00	101,080,000.00
120009	Бусад орлого	1,226,902,900.00	527,096,020.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,355,099,289.68	1,250,430,466.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,355,099,289.68	1,250,430,466.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,039,959.00	64,279,961.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,039,959.00	64,279,961.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,039,959.00	64,279,961.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,240,059,330.68	1,186,150,505.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	479,691,946.00	470,544,472.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	479,691,946.00	470,544,472.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	525,054,611.00	373,699,211.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	525,054,611.00	373,699,211.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	129,960,000.00	68,080,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,960,000.00	68,080,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,105,352,773.68	273,826,822.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,105,352,773.68	273,826,822.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(53,684,789.68)	114,887,853.65
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)	(53,684,789.68)	114,887,853.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,615,746,516.00	1,365,318,320.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,615,746,516.00	1,365,318,320.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,615,746,516.00	1,365,318,320.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,615,746,516.00	1,365,318,320.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	944,551,600.00	737,142,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129,960,000.00	101,080,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,541,234,916.00	527,096,020.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,721,099,289.68	2,402,316,242.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,721,099,289.68	2,402,316,242.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,039,959.00	64,279,961.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,039,959.00	64,279,961.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,039,959.00	64,279,961.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,606,059,330.68	2,338,036,281.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,845,691,946.00	1,622,430,248.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,845,691,946.00	1,622,430,248.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	525,054,611.00	373,699,211.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	525,054,611.00	373,699,211.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	129,960,000.00	68,080,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,960,000.00	68,080,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,105,352,773.68	273,826,822.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,105,352,773.68	273,826,822.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,105,352,773.68)	(1,036,997,922.35)
14	Бусад эх үүсвэр	1,105,352,773.68	1,036,997,922.35
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	1,105,352,773.68	1,036,997,922.35
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,105,352,773.68	1,036,997,922.35
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	-	2,276,590,585.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	-	2,276,590,585.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(53,684,789.68)	-	(53,684,789.68)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,222,905,795.32	-	2,222,905,795.32
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	2,222,905,795.32	-	2,222,905,795.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,222,905,795.32	-	2,222,905,795.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	114,887,853.65	-	114,887,853.65
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,337,793,648.97	-	2,337,793,648.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,110,008,320.00	1,677,710,209.00	(432,298,111.00)	79.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,110,008,320.00	1,677,710,209.00	(432,298,111.00)	79.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,277,008,320.00	890,539,109.00	(386,469,211.00)	69.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,000,000.00	33,000,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	800,000,000.00	754,171,100.00	(45,828,900.00)	94.3
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,110,008,320.00	1,677,710,209.00	(432,298,111.00)	79.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,110,008,320.00	1,677,710,209.00	(432,298,111.00)	79.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,800,000.00	64,279,961.00	(20,520,039.00)	75.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,800,000.00	64,279,961.00	(20,520,039.00)	75.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,800,000.00	64,279,961.00	(20,520,039.00)	75.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,025,208,320.00	1,613,430,248.00	(411,778,072.00)	79.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,025,208,320.00	1,613,430,248.00	(411,778,072.00)	79.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,025,208,320.00	1,613,430,248.00	(411,778,072.00)	79.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 84,000.0 мянган төгрөгийн 1 алдааг¹ аудитын явцад залруулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тулгалтыг шалгахад батлагдсан төсвийг 84,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 7.1, 7.2 дахь хэсэг, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн "Толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд нэмж тусгаж залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тулгалтыг шалгахад батлагдсан төсвийг төсвийн тодотголын дүнгээс 84,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	84,000.0	1	84,000.0	-	-	1	84,000.0	-	-	-	-
Дүн	1	84,000.0	1	84,000.0	-	-	1	84,000.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим системд нийт 3,964,773.9 мянган төгрөгийн 123 мэдээллийг хоцроож, 29,108.0 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.	1	3,993,881.9	-	-	1	3,993,881.9	-	-
Дүн	1	3,993,881.9	-	-	1	3,993,881.9	-	-